



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/11/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхцэцэг Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn Аудитор: Т.Мөнхтогтох Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn
---	---



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,

Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Холбоо. 08.08 № 1-6/308

танай _____ -ны № _____ -т

УЛААНБАДРАХ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Г.ГАНБҮРЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

010020151

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	970.1	1,668.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,667.8	5,756.4
	Нийт хөрөнгийн дүн	5,637.9	7,425.0
	Нийт өр төлбөрийн дүн	11.2	16.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,626.8	7,408.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,638.0	7,425.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,188.0	4,361.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,416.8	2,381.2
	Үйл ажиллагааны үр дүн	771.2	1,980.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	69.6	128.7
	Үйл ажиллагааны нийт үр дүн	701.6	1,851.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,850.2	2,774.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,203.4	1,801.8
	Үйл ажиллагааны ЦМГ	646.8	972.7
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-474.4	-662.5
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	172.4	310.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	105.4	277.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	277.8	588.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,925.3	5,626.8
	Тайлант оны үр дүн	701.5	1,851.8
	Эцсийн үлдэгдэл	5,626.8	7,408.2
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,055.3	2,331.2
	Урсгал зардал	1,647.3	1,704.8
	Хөрөнгийн зардал	408.0	626.4
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,210.4	2,643.1
	Улсын төсвөөс санхүүжих	1,550.2	1,743.1
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	575.9	786.8
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14.9	12.5
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	69.4	100.7

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаанбадрах сум нь эрхэм зорилгоо “Хүний хөгжил, өв соёлоо дээдэлж, ирээдүйдээ үлдээх баялагтай, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах” гэж тодорхойлсон байна.

Тайлант онд Засаг даргын дэргэдэх тасаг, албад нь Тамгын газраас боловсруулж, Засаг даргын шийдвэрлэсэн бодлогыг хэрэгжүүлэх, оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 153 мэдээллээс 151 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага, сан түүврээр хамрагдсан байна. Сургуулийн ахмадын сан болон нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулж, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ болон холбогдох ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 4 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн ба зөрчилтэй дүгнэлт авсан байгууллага үгүй болно.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 1 алдаа, зөрчил илрүүлснээс 0.6 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд Ерөнхий боловсролын сургууль нь аудит хийгдсэн тайлангаас 0.6 сая төгрөгийн бараа материалыг илүү нэгтгэн тайлагнасныг аудитын явцад залрууллаа.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,277.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,265.4 сая төгрөгийн 23 алдааг аудитын явцад залруулж, 5.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 15 албан шаардлага хүргүүлж, 6.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 12 зөвлөмжийг хүргүүллээ.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								Дүгнэлтийн хэлбэр
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	ИТХ	5	7.0	2	7.0	-	-	1	-	2	-	зөрчилгүй
2	ЗДТГ	9	794.4	3	792.8	-	-	3	0.2	3	1.4	зөрчилгүй
3	ЭМТ	5	21.7	2	21.7	-	-	2	-	1	-	зөрчилгүй
4	ЕБС	8	249.9	2	249.4	-	-	4	-	2	0.5	зөрчилгүй
5	Цэцэрлэг	11	27.9	6	19.7	-	-	3	4.4	2	3.8	түүвэр
6	Соёлын төв	6	18.8	2	16.9	-	-	2	1	2	0.9	түүвэр
7	ОНХС	4	1151.7	4	1151.7	-	-	-	-	-	-	түүвэр
8	СХС	2	6.2	2	6.2	-	-	-	-	-	-	түүвэр
9	ТТЗ	1	0.6	1	0.6	-	-	-	-	-	-	зөрчилгүй
	НИЙТ	51	2278.2	24	2266.0	-	-	15	5.6	12	6.6	-